



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/271

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25, 31 дүгээр зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4.7 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын шийдвэрээр данс бүртгэлээс хасагдаж Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт татан төвлөрүүлэхээр шийдвэрлэгдсэн эд хөрөнгийг худалдан борлуулах үнийг тогтоох, борлогдох боломжгүй хөрөнгийг устгах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Данснаас хасч татан төвлөрүүлсэн хөрөнгийг худалдан борлуулах, борлогдох боломжгүй хөрөнгийг устгалын акт үйлдэн устгах ажлыг зохион байгуулж, үнэлгээг зохих хууль журмын дагуу хийж, тайланг улирал бүр танилцуулахыг Ажлын хэсэг /Д.Төмөрбаатар/-т даалгасугай.


3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/107 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 17 дугаар сарын
26 -ний өдрийн 8/12/ тушаалын нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Төмөрбаатар

Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч

Гишүүд:

...

Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын хэлтсийн
даргын үүрэг гүйцэтгэгч

Н.Раднаасэд

Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын хэлтсийн
ахлах мэргэжилтэн

Н.Золжаргал

Захиргаа санхүүгийн хэлтсийн ахлах, хүний
нөөцийн мэргэжилтэн

Н.Уранчимэг

Ерөнхий нягтлан бодогч

Б.Мөнхбаатар

Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын хэлтсийн
мэргэжилтэн

Зөвлөлийн нарийн бичгийн
дарга:

Т.Оюунтуул

Захиргаа санхүүгийн хэлтсийн нягтлан бодогч